



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын
2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/24/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот
2015 оны 4 дүгээр сар



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

АГУУЛГА

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ
Хавсралт 2: Менежментийн захидал
Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан
Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер: Л.Одгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
odgerell@audit.gov.mn

Аудитор: Ц.Цэрэнхүү
Утас: 263809
Цахим хаяг:
Tserenkhuits@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /ҮАГ-/2015/24/СТА-ТЕЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 04 дүгээр сарын 03-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2014 оны 04 дүгээр сарын 15-наас 2014 оны 04 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайдад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Ерөнхий сайд нь үндсэн үйл ажиллагаагаа Монгол Улсын “Үндсэн хууль”, “Засгийн газрын тухай хууль”, “Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн нууцын тухай хууль”, “Цөмийн энергийн тухай хууль”, “Харилцаа холбооны тухай хууль”, “Жендэрийн эрх тэгш байдлыг хамгаалах тухай хууль”, “Авлигын эсрэг тухай хууль”, “Тагнуулын тухай хууль”, “Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль”, “Шуудангийн тухай хуулиуд”, “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”, санхүү, төсвийн талаарх үйл ажиллагаагаа Монгол улсын “Төсвийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”,

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” зэрэг хуулиудын хүрээнд явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Монгол Улсын “Төсвийн тухай” хуулийн 14.1.4-д “Монгол Улсын Ерөнхий сайд нь түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч байна” гэж заасан бөгөөд дараах үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Жендерийн эрх тэгш байдлыг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд салбарын болон орон нутгийн чадавхийг сайжруулж, жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг бүх түвшний бодлого, үйл явцад нэвтрүүлэх, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн олон талт оролцоог хангах, нөөц бололцоо, санхүүжилтийн тогтвортой байдлыг бий болгох, олон улсын хамтын ажиллагааг уялдуулах;
- Төр, компани, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, тэгш оролцоог бүрдүүлэх замаар олборлох үйлдвэрлэл эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигч компани улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрөө, Засгийн газар компаниас хүлээн авсан орлогоо ил тодоор тайлагнан нийтэд мэдээлэх үйл ажиллагааг хэвшүүлэх, зөрүүтэй байдлыг аудитор тодорхойлж, авилгалаас урьдчилан сэргийлэх орчинг бүрдүүлж, уул уурхайн орлогын менежементийг сайжруулах;
- Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглахтай холбоотой хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, цацраг идэвхт ашигт малтмалын эрэл, хайгуул, судалгааг хөгжүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх, олборлох, боловсруулалт явуулах ажлыг зохион байгуулах, цөмийн технологийн энхийн хэрэглээг хөгжүүлэх, нэвтрүүлэх цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, эрдэм, шинжилгээ, туршилт судалгааны ажлыг өргөжүүлэх, хүний нөөц бэлтгэх, салбарын удирдлага зохион байгуулалт, хяналтын тогтолцоог оновчтой бүрдүүлэх;
- Түүх соёлын уламжлал, шинэчлэл, нийгмийн амьдралын бодит үнэн байдал, эдийн засгийн ололт амжилтыг гадаадын улс орнуудад түгээн дэлгэрүүлж сурталчлах, улс орны амьдралд болж буй үйл явдал, дэлхий дахины тухай мэдээ мэдээллийг шуурхай, үнэн бодитой хүргэх;
- Тагнуулын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын өөрчлөлтийн хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны стратегийн зорилт, гол зорилт, тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, захиргааны болон мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах, хэрэгжилтийн явц байдалд нь хяналт, шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх, гадаад тагнуул, сөрөх тагнуулын үйл ажиллагаа явуулах, хуулиар харьяалуулсан гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлаар

мэдээлэл боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах замаар үйл ажиллагааны эрхэм зорилгод хүрэх тал бүрийн нөхцлийг бүрдүүлэх;

- Улс төр нийгэм эдийн засгийн бүхий л хүрээнд мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбоог нэвтрүүлж, төрийн удирдлагын үр нөлөө, төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, МТХХ-ны дэд бүтцийг хөгжүүлэх, мэдээлэл хүртэх тэгш бус байдал, тоон ялгааг арилгах, хууль зүйн тааламжтай орчинг бүрдүүлэхэд төрөөс баримтлах бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж мэдээлжсэн нийгмийг байгуулах;
- Төрийн тусгай хамгаалалтын газрын алсын хараа нь эрхэм зорилгыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын шинэ бүтцийг бий болгон төлөвшүүлж, хуулиар төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, иргэний амь бие, ордон өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийн аюулгүй байдлыг мэргэжлийн болон бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор үйл ажиллагаагаар хангаж, цаг тухайд нь найдвартай иж бүрэн хамгаалалт үзүүлэх;

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон, тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 4-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тус багцын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй танилцахад салбарын хэмжээнд ЗГХЭГазрын даргын 2007 оны 192 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

МУЕС -ын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланг төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах аргачлал, зааврын дагуу санхүүгийн тайланг

“Plastik”, тайлангийн нэгтгэлийг санхүүгийн “Е-тайлан”- програмыг тус тус ашиглаж байна.

Төсвийн багцын материаллаг байдлын түвшинг төсвийн санхүүжилтийн дүн 124.216.0 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 2.484.3 сая төгрөгөөр баталгаажууллаа.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. ЗГХЭГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад “хэвийн” байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

2014 онд төлөвлөгөөгөөр 139,594.2 сая төгрөг зарцуулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 124,216.0 сая төгрөг зарцуулсан байна.

Шилэн дансны тухай мэдээлэл

Тус багцын байгууллагууд Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу 19 хавсралтаар мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Тайлагналын үе шатанд аудитын 4 чиглэлээр эрсдэлүүдийг тогтоон, түүнд тавигдах хяналтуудыг үнэлэхэд үр нөлөөтэй байгаа тул нарийвчилсан сорилын аргаар даган мөшгих сорилыг хийлээ.

Үйлчлүүлэгчээс авсан судалгаа, тоон мэдээлэл, тайлбар, тодорхойлолт, нотлох баримтуудыг тусгайлан СТАУС програмд хадгалав.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

МУЕС -ын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, авлага, зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын харьяа агентлаг, байгууллагуудад хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл өмнөх оноос 2,119.3 сая төгрөгөөр нэмэгдэж, жилийн эцэст 13,417.4 сая төгрөгт хүрсэн бөгөөд үүний дотор 5,393.7 сая төгрөгийн хэрэгжиж дууссан ажил үйлчилгээ, сургалтын төсөл, 3,634.7 сая төгрөгийн гэрээний хугацаа болоогүй төсөл, хэрэгжиж дууссан боловч хаана шилжиж бүртгэгдэхийг эрх зүйн хувьд шийдвэрлэж чадаагүй 4,388.8 сая төгрөгийн хөрөнгө байна.

Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бий болсон хөрөнгийг төрийн өмчид хэрхэн бүртгэх, үзүүлсэн ажил, үйлчилгээг хэрхэн зардалд бүртгэх асуудлыг олон жил шийдвэрлэлгүй хуримтлагдсан, төсөл, арга хэмжээ, ажил үйлчилгээний баталгаат хугацаа дуусаагүй, зарим хөрөнгө оруулагч тал хөрөнгийг бүртгэхээс татгалздаг зэрэгтэй холбоотой байна.

Өмнөх онд ЯАГ-аас хийсэн аудитаар дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэлийг багасгах талаар ТӨХ болон бусад байгууллагад хандаж шийдвэрлэх талаар зөвлөмж өгсөн боловч өнөөдрийн байдлаар тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Шийдвэрлэсэн: Иймд уг асуудлыг шийдвэрлэх талаар аудитын зөвлөмж өгөх

- Тус сан нь Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн дагуу харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч 543 байгууллагаас улсын төсөвт 3,927.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 3,214.5 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 712.0 сая төгрөгөөр буюу 18.2 хувиар тасалдуулсан байна.

Энэ нь харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын төлбөрийн чадвар муудаж, төлбөр төлөх хугацаа хойшлогдсон, тайлант оны 4-р улирлын төлбөр нь дараа онд дамжин төлөгддөг, зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давхар бизнес эрхэлдэг бол нийт борлуулалтын орлогоос зөвхөн харилцаа холбооны орлогыг салгаж татвар төлөх хүсэлт ирүүлдэг зэрэгтэй холбоотой байна.

2014 оны жилийн эцсийн байдлаар 2010-2014 онуудад үүссэн 107 байгууллагын 624.5 сая төгрөгийн хуримтлагдсан авлага үүссэн байна.

Шийдвэрлэсэн: Улсын төсвийн орлого тасалдсан дээр дурдсан шалтгаан, үндэслэлийг судлан эрх зүйн актанд өөрчлөлт оруулах саналыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх талаар аудитын зөвлөмж өгөх

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын олон улсын стандартын дагуу аудитын явцад илрүүлсэн санхүүгийн тайланд залруулаагүй материаллаг биш аливаа алдаа, зөрчлийг тухайн байгууллагын удирдлагын анхааралд хандуулах шаардлагатай байдаг.

Дээрх шаардлагын дагуу энэ удаагийн аудитаар илэрсэн зарим алдаа, зөрчлийг арилгах, цаашид дахин давтан гаргахгүй байхыг аудитын явцад үүрэг болгож, асуудлын бүртгэлд 3 асуудал тусгаж, тус газрын удирдлагад асуудлын мөрөөр холбогдох арга хэмжээ авахуулахаар зөвлөмж өгсөн болно. Зөвлөмжийг тусгайлан Менежементийн захидалд тусгасан болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн талаар

МУЕС-ын төсвийн багцад харьяалагддаг агентлаг байгууллагуудаас нийт 13 байгууллага аудитад хамрагдсанаас 11 байгууллагад зөрчилгүй санал дүгнэлт, 2 байгууллагад хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 38,940.3 сая төгрөгийн зөрчил илэрсэний 14,140.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах талаар 6 албан шаардлага, 24,799.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах талаар 33 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 1 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2014 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд 316,2 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгаж, ажлын хариуцлага алдсан холбогдох ажилтанд сахилгын шийтгэл ноогдуулах арга хэмжээ авсан байна.

Зөвлөмж

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөв.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд

холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн , шударга илэрхийлэгдсэн байна.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Асуудал 1: Дуусаагүй үйлдвэрлэлийн үлдэгдлийн талаар

Асуудал 2: Төсвийн орлогын бүрдүүлэлтийн талаар

Асуудал 3: Аудитаар илэрсэн зөрчлийн талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг, хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

ҮАГ-ын ажиглалт

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл өмнөх оноос 2,119.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 2014 оны жилийн эцэст 13,417.4 сая төгрөгт хүрсэн бөгөөд үүнийг дотор нь задалж үзвэл нь 5,393.7 сая төгрөгийн хэрэгжиж дууссан ажил үйлчилгээ, сургалтын төсөл, 3,634.7 сая төгрөгийн гэрээний хугацаа болоогүй төсөл, хэрэгжиж дууссан боловч хаана шилжиж бүртгэгдэхийг эрх зүйн хувьд шийдвэрлэж чадаагүй 4,388.8 сая төгрөгийн хөрөнгө байна.

ҮАГ-ын зөвлөмж

Иймд хэрэгжиж дууссан 9,782.5 сая төгрөгийн төслийн хөрөнгийг холбогдох /эзэмшигч/ байгууллагын данс бүртгэл, зардалд тусгах асуудлыг ТӨХ-гоор шийдвэрлүүлэн, дуусаагүй үйлдвэрлэл дансны хуримтлагдсан үлдэгдлийг бууруулах арга хэмжээ авах, зөвлөмжийн биелэлтийг 2015 онд багтаан ҮАГ-т албан ёсоор гаргаж ирүүлэх.

Эрсдэлүүд

Өмч хөрөнгө эзэнгүйдэх, үрэгдэх,

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг сангийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан.

Асуудал 2: Төсвийн орлогын бүрдүүлэлтийн талаар**Тэргүүлэх ач холбогдол №2****ҮАГ-ын ажиглалт**

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн дагуу харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч 543 байгууллагаас улсын төсөвт 3,927,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 3,214,5 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 712,0 сая төгрөгөөр буюу 18,2 хувиар тасалдуулсан байна.

ҮАГ-ын зөвлөмж

Иймд улсын төсвийн орлого тасалдсан дээр дурдсан шалтгааныг судлан, шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль, журамд тухайлбал: “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, “ Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4-д өөрчлөлт оруулах асуудлыг судлан шийдвэрлэх, зөвлөмжийн биелэлтийг 2015 онд багтаан ҮАГ-т албан ёсоор гаргаж ирүүлэх

Эрсдэлүүд

Төсвийн тухай хууль зөрчигдөх, төсвийн орлого тасалдах

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

МУЕС-ын төсвийн багцад харьяалагддаг агентлаг байгууллагуудаас нийт 13 байгууллага аудитад хамрагдсанаас 11 байгууллагад зөрчилгүй санал дүгнэлт, 2 байгууллагад хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 38,940.3 сая төгрөгийн зөрчил илэрсэний 14,140.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах талаар 6 албан шаардлага, 24,799.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах талаар 33 зөвлөмж өгсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Иймд “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан нэр бүхий байгууллагын холбогдох албан тушаалтанд “Төрийн аудитын тухай” хуульд заасны дагуу хариуцлага тооцох, зөвлөмжийн биелэлтийг 2015 онд багтаан ҮАГ-т албан ёсоор гаргаж ирүүлэх

Эрсдэлүүд

Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу гарах

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан болно.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЧИМЭДИЙН САЙХАНБИЛЭГ
ТАНАА

2015.04.24 № 488
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

 А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
НИЙТ ДҮН	-	-
МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,230,460,554.84	5,307,633,882.83
Кассанд байгаа бэлэн мөнгө	34,097,259.54	206,247,104.12
Төгрөг\ ЖМС	34,097,259.54	206,247,104.12
Банкинд байгаа бэлэн мөнгө	4,196,363,295.30	5,101,386,778.71
Төгрөг	4,196,363,295.30	5,101,386,778.71
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	3,335,066,827.24	3,713,939,330.96
Нэмэлт санхүүжилтийн харилцах	861,296,468.06	1,387,447,447.75
АВЛАГА	1,749,286,132.19	6,970,154,358.67
Ажиллагчидтай холбогдсон авлага	91,567.71	938,385.00
Төлбөртэй үйлчилгээний авлага	755,189,886.10	2,437,146,478.43
Бусад авлага	994,004,678.38	4,532,069,495.24
Байгууллагаас авах авлага	811,106,653.05	4,339,773,971.46
Гэрэл цахилгааны авлага	487,221.00	459,167.00
Дотоод албан томилолтын авлага	-	39,000.00
Бусад зардлын тооцооны авлага	810,619,432.05	4,339,275,804.46
Хувь хүмүүсээс авах авлага	182,898,025.33	192,295,523.78
УРЬДЧИЛГАА	10,217,855,428.38	4,679,271,922.39
Бусад урьдчилгаа	10,217,855,428.38	4,679,271,922.39
Урьдчилгаа тооцоо	509,763,802.38	290,326,351.39
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	35,373,419.82	8,558,098.24
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	159,815,678.80	142,775,940.80
Цалингийн урьдчилгаа	1,263,182.00	-
Бусад урьдчилгаа	313,311,521.76	138,992,312.35
Урьдчилж гарсан зардал	9,708,091,626.00	4,388,945,571.00
Урьдчилж төлсөн зардал	9,708,091,626.00	4,388,945,571.00
БАРАА МАТЕРИАЛ	87,211,543,917.66	87,954,403,812.52
Түүхий эд материал	83,983,384,966.12	84,405,495,417.12
Тусгай зориулалттай материал	784,704,899.58	799,962,010.63
Эм боох материал	30,317,742.00	30,806,670.00
Дуусаагүй үйлдвэрлэл	74,537,384,944.55	83,545,115,529.27
Бэлэн бүтээгдэхүүн	8,630,977,379.99	29,611,207.22
Хангамжийн материал	2,378,327,142.80	2,508,614,735.01
Бичиг хэргийн материал	78,273,335.79	40,261,109.68
Аж ахуйн материал	942,189,251.66	1,058,471,774.03
Сэлбэг хэрэгсэл	960,492,728.73	967,405,211.40
Түлш, шатах тослох материал	145,723,154.72	117,500,048.92
Барилгын засварын материал	276,232.12	-
Хүнсний материал	49,843,575.56	39,903,966.00
Бусад бараа материал	201,528,864.22	285,072,624.98

Мал амьтад	45,584,000.00	46,555,000.00
Бусад	804,247,808.74	993,738,660.39
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	103,409,146,033.07	104,911,463,976.41
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	75,276,080,320.75	89,928,374,365.65
Биет хөрөнгө	73,232,174,877.41	86,018,076,035.04
Барилга, байгууламж, орон сууц	22,361,046,632.70	32,106,863,826.30
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	51,409,177,558.18	63,121,700,181.60
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(29,048,130,925.48)	(31,014,836,355.30)
Авто-тээврийн хэрэгсэл	4,720,760,042.84	6,645,774,670.71
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	10,439,248,086.46	15,315,942,491.07
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(5,718,488,043.62)	(8,670,167,820.36)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	25,546,722,265.53	38,724,192,783.02
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	55,088,216,582.94	75,054,574,122.04
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(29,541,494,317.41)	(36,330,381,339.02)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,377,880,655.41	1,443,018,246.73
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	3,020,256,752.85	3,317,320,113.04
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(1,642,376,097.44)	(1,874,301,866.31)
Бусад үндсэн хөрөнгө	173,009,401.43	157,816,816.78
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	310,362,400.96	311,889,571.96
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(147,223,901.43)	(162,995,470.18)
Номын фонд	9,870,901.90	8,922,715.00
Дуусаагүй барилга, байгууламж	19,052,755,879.50	6,940,409,691.50
Биет бус хөрөнгө	2,043,905,443.34	3,910,298,330.61
Програм хангамж	2,045,385,276.70	3,912,432,163.97
Програм хангамж - Анхны өртөг	3,624,476,436.63	6,582,535,468.75
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(1,579,091,159.93)	(2,670,103,304.78)
Бусад биет бус хөрөнгө	(1,479,833.36)	(2,133,833.36)
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(1,479,833.36)	(2,133,833.36)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	178,685,226,353.82	194,839,838,342.06
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,258,616,758.98	5,335,690,603.97
Өглөг	523,456,672.03	4,661,997,591.05
Ажилчидтай холбогдсон тооцоо	1,141,156.22	1,065,000.13
Цалингийн өглөг	743,249.29	743,249.29
ХАОАТ-ын өглөг	397,906.93	321,750.84
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	48,493,398.50	670,913,614.56
Бусад зардлын тооцоо	48,493,398.50	670,913,614.56
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн тооцоо	278,417,095.99	318,074,762.00

Бусад өглөг	195,405,021.32	3,671,944,214.36
Байгууллагад төлөх өглөг	187,749,676.18	3,617,079,004.02
Хувь хүмүүст төлөх өглөг	7,655,345.14	54,865,210.34
Урьдчилж орсон орлого	735,160,086.95	673,693,012.92
Төсөвт байгууллага	735,160,086.95	673,693,012.92
Урьдчилж орсон орлого	735,160,086.95	673,693,012.92
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,258,616,758.98	5,335,690,603.97
Засгийн газрын хувь оролцоо	177,426,609,594.84	189,504,147,738.09
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	54,356,530,731.81	61,122,287,932.95
Хуримтлагдсан үр дүн	116,164,236,833.25	121,442,985,296.80
Өмнөх үеийн үр дүн	116,164,236,833.25	115,852,703,618.98
Тайлант үеийн үр дүн	-	5,590,281,677.82
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,905,842,029.78	6,938,874,508.34
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	177,426,609,594.84	189,504,147,738.09
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	178,685,226,353.82	194,839,838,342.06

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
НИЙТ ДҮН	-	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	109,669,040,088.64	133,125,294,219.34
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	109,669,040,088.64	133,125,294,219.34
Улсын төвлөрсөн төсвөөс	97,231,358,516.33	110,185,939,861.57
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	38,747,068,417.00	58,006,379,391.27
Засгийн газрын нөөц хөрөнгө	69,717,839.00	-
Хөрөнгийн	57,519,268,683.70	50,019,861,679.00
Тусламжийн сангаас санхүүжих	298,017,570.90	636,514,816.20
Нэмэлт санхүүжилтийн орлого	597,286,005.73	1,523,183,975.10
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	40,800,805.00	113,770,602.30
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	215,488,800.73	295,366,239.80
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,400,000.00	879,686,433.00
Төсвийн урамшуулал	296,596,400.00	234,360,700.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	10,432,720,640.87	7,112,595,756.09
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	31,475,056.00	-
Хөрөнгийн	10,401,245,584.87	7,112,595,756.09
Нийгмийн даатгалын сангаас	24,378,372.00	19,383,336.00
НДС-ийн шилжүүлэг	24,321,882.00	19,383,336.00
ЭМДС-ийн шилжүүлэг	56,490.00	-
Бусад Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	1,980,582,559.44	15,807,375,265.68
Төрийн сургалтын санд олгох	2,110,200.00	-
Төрийн албан хаагчын 1 хүүхдийн сургалтын төлбөр	2,110,200.00	-
Гадаад төслийн зээлээс санхүүжих	1,978,472,359.44	15,807,375,265.68
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,267,563,831.25	53,218,476,086.09
Өмчийн орлого	-	7,366,922,733.52
Хүүгийн орлого	-	29,133,352.49
Ногдол ашиг	-	6,469,327,793.36
Түрээсийн орлого	-	868,461,587.67
Төрийн өмч түрээслүүлсний орлого	-	868,461,587.67
Бараа, үйлчилгээний борлуулалт	23,267,563,831.25	33,700,992,091.57
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	23,267,563,831.25	33,700,992,091.57
Үндсэн үйл ажиллагааны орлого	12,227,566,335.30	13,492,890,920.29
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1,859,636,523.16	11,513,463,894.81

Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,180,360,972.79	8,694,637,276.47
Тусламжаас бусад шилжүүлэг	-	12,150,561,261.00
Өмч хувьчлалын орлого	-	12,150,561,261.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	132,936,603,919.89	186,343,770,305.43
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	22,935,272,158.73	34,019,748,137.91
Үндсэн болон нэмэгдэл цалин	21,765,409,227.29	32,397,524,533.45
Үндсэн цалин	20,753,494,873.29	31,045,296,262.17
Гэрээт ажилчдын цалин	36,020,000.00	29,667,245.00
Унаа хоолны хөнгөлөлт	-	1,322,561,026.28
Бусад нэмэгдлүүд	975,894,354.00	-
Унаа, болон бусад нөхөн олговор	975,894,354.00	-
Нийгмийн хамгааллын шимтгэл	1,169,862,931.44	1,622,223,604.46
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	740,834,361.52	1,010,714,249.91
Тэтгэврийн даатгалын шимтгэл	581,011,757.49	818,400,512.17
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	59,849,389.49	73,376,005.15
